



ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Эвлэрүүлэн зуучлагчдын
зөвлөлийн гишүүн
Б.Энх-Эрдэнэ

2022.11.04.




Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль



ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

- Шүүх дэх
- Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь



ШҮҮХ ДЭХ

- ШЕЗ нь ЭЗЗ-өөр дамжуулан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 11.1-д заасан эрхийг хэрэгжүүлэх;
- Шүүхийн тухай хуулийн 71.1.16-д “шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах”;
- Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 7.2-д “эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагыг ШЕЗ болон тухайн шүүхийн тамгын газар хариуцаж, холбогдох төсвийг тухайн шүүхийн төсвөөс гаргана”;



Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь

ШЕЗ нь ЭЗЗ-өөр дамжуулан Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 11.1-д заасан дараах эрхийг хэрэгжүүлэхэд оролцох;

1. Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах;
2. Эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох;
3. Эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах;
4. Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах;




2022 оны 3 дугаар улирлын байдлаар

Монгол Улсын шүүх 2022 оны 3 дугаар улиралд шүүхийн бус журмаар маргаанаа шийдвэрлүүлэхийг хүссэн нийт 17472 нэхэмжлэл, хүсэлт, өргөдөл хүлээн авчээ. Үүнээс 17069 нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл, 403 нь шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлсэн иргэний хэрэг байна.


- * Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 17069 өргөдлийн 3411 буюу 20.0 хувийг журмын дагуу хүлээн авахаас татгалзаж, 1889 буюу 11.1 хувийг хүсэлт гаргагч өөрийн хүсэлтээр эргүүлэн татаж 10369 буюу 62.8 хувийг шийдвэрлэж, 1400 өргөдлийн үлдэгдэлтэй байна.

* **График№1. Шүүх дэх Эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл.**



Шийдвэрлэсэн нийт 10369 өргөдлийн 6515 буюу 62.8 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 3854 буюу 37.2 хувьд нь эвлэрэл амжилтгүй болжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал эвлэрэл амжилттай болсон хувь 3.3 хувиар буурсан байна.


* *График №2. Шийдвэрлэсэн өргөдлөөс амжилттай байдал (хувь)*



2022 оны 3-р улирлын байдлаар нийт 32423 (хэрэгсэхгүй болгосон хэргийг хассанаар) иргэний хэрэг шийдвэрлэсэн бол шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар 6515 өргөдлийг амжилттай шийдвэрлэсэн нь иргэний хэргийн 16.8 хувьтай тэнцүү байна. Энэ нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг 17 орчим хувиар бууруулсан гэж хэлж болно.

Иргэний эрх зүйн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа бол гэр бүлийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлахад хүндрэлтэй байгаа нь харагдаж байна. Мөн хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хувьд эвлэрүүлэн зуучлагчид хандахаас илүүтэй шүүхээр шийдвэрлүүлэх хандлагатай байна.

* **График №3. 2022 оны 3-р улиралд шийдвэрлэсэн иргэний хэрэг болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн өргөдөл**



Монгол Улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 2022 оны 3-р улирлын дүнг өнгөрсөн оны дүнтэй харьцуулбал: Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл 23.9 хувиар, шийдвэрлэсэн өргөдөл 27.9 хувиар, шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг 29.6 хувиар тус тус өссөн дүнтэй гарсан бол тайлангийн эцсийн үлдэгдэл 4.0 хувиар буурсан дүнтэй гарсан байна. Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл хүлээж аваагүй байна.

Хүснэгт №1. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүн /харьцуулалт/

№	Үзүүлэлт		3-р улирал		Өсөлт, бууралт	
			2021 он	2022 он	Зөрүү	Хувь
1	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөл		13781	17069	3288	23.9
2	Үүнээс	Хүлээн авахаас татгалзсан	2295	3411	1116	1.5
3		Хүсэлт гаргагч өргөдлөө буцаасан	1905	1889	-16	-0.8
4		Шийдвэрлэсэн	8108	10369	2261	27.9
5		Үлдэгдэл	1473	1400	-73	-5.0
6	Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл		0	0	0	-
7	Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн иргэний хэрэг		311	403	92	29.6
8	Тайлангийн үеийн эцсийн үлдэгдэл		1512	1452	-60	-4.0


Эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдлөөр шийдвэрлэсэн нийт 10369 өргөдлийн 7609 хэрэг буюу 73.4 хувь нь иргэний эрх зүйн маргаан, 2683 хэрэг буюу 25.9 хувь нь гэр бүлийн эрх зүйн маргаан, 25 хэрэг буюу 0.2 хувь нь хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан, 52 буюу 0.5 хувь нь урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан өргөдөл байна.

График №4. Эвлэрүүлэн зуучлагчийн шийдвэрлэсэн маргааны төрөл




* Иргэний эрх зүйн нийт шийдвэрлэсэн 7609 маргааны 6248 буюу 82.1 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай, 1361 буюу 17.9 хувьд нь эвлэрэл амжилтгүй, гэр бүлийн эрх зүйн нийт шийдвэрлэсэн 2683 маргааны 239 буюу 8.9 хувьд эвлэрэл амжилттай, 2444 буюу 91.1 хувьд амжилтгүй болсон бол хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хувьд нийт шийдвэрлэсэн 25 хэргээс 10 нь эвлэрэл амжилттай, 15 нь амжилтгүй, урьдчилан шийдвэрлэх журмаар гаргасан 52 өргөдлийн 18 буюу 34.6 хувьд нь амжилттай, 34 буюу 65.4 хувьд нь эвлэрэл амжилтгүй болсон байна.


График 5.5 Эвлэрэл амжилттай явагдсан байдал /маргааны төрлөөр/



* Шүүхээс иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн 403 иргэний хэргийн 65 хэрэгт нь эвлэрэл амжилттай болж, 286 хэрэгт эвлэрэл амжилтгүй болж 52 хэргийн үлдэгдэлтэй байна. Шүүхээс иргэний хэрэг үүсгэхээс өмнө шилжүүлэн ирсэн нэхэмжлэл байхгүй байна.

График №6. Иргэний хэрэг үүсгэсний дараа шилжүүлэн ирсэн хэрэг







Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага

ШҮҮХ ДЭХ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 9 дүгээр зүйл

- 9.1.1. Эрх зүйн бүрэн чадамжтай байх;
 - 9.1.2. Дээд боловсролтой байх;
 - 9.1.3. Эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх;
 - 9.1.4. Эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх;
 - 9.1.5. Ял шийтгэлгүй байх,
- 9.2. Эвлэрүүлэн зуучлагч нь үйл ажиллагаандаа энэ хуулийн 10.1-д заасан эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрэм болон бусад журмыг баримтлан ажиллана.

ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО ДАХЬ

Адил + мэргэшсэн байх



Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам ба эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах талаар

Шүүх дэх

- Эвлэрүүлэн зуучлах тухай хуульд заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам
- Талуудад мэдэгдэх хуудсыг ИХШХШТХ-ийн 77-р зүйлд заасны дагуу
- Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана.

Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь

- Эвлэрүүлэн зуучлах тухай хуульд заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам
- Талууд болон холбогдох этгээдэд гэрийн хаяг, шуудангийн хаягийн дагуу мэдэгдэх хуудсаар эсхүл утсаар
- Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

БАЯРЛАЛАА

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧДЫН
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.ЭНХ-ЭРДЭНЭ

